



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/612

Улаанбаатар хот

┌ Сонгинохайрхан дүүргийн 17 дугаар ┐  
хорооны "Санхум" өрхийн эрүүл мэндийн төвийн  
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,906,000 /гурван сая зуун есөн зургаан мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 17 дугаар хорооны "Санхум" өрхийн эрүүл мэндийн төв /З.Алтанцэцэг/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 2 нэр төрлийн 348,000 /гурван зуун дөчин найман мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 6 нэр төрлийн 3,558,000 /гурван сая таван зуун тавин найман мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 17 дугаар хорооны "Санхум" өрхийн эрүүл мэндийн төв /З.Алтанцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГА



М. БАЯРАА

115060001477



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 14-р сарын 14-ны өдрийн 4074-р тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: СХД-ийн 17-р хорооны "Санхум" ӨЭМТ

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	НӨАУ-ын мэргэжилтний дүгнэлт	ЭБХХХК-н шийдвэр
1	Шарлагын аппарат	10	ш	1	1,600,000.00	1,600,000.00	1,600,000.00	-		Атлах	Татах	
2	Гүйлттийн зам	10	ш	1	315,000.00	315,000.00	315,000.00	-		Атлах	Татах	
3	Унадаг дугуй	10	ш	1	268,000.00	268,000.00	268,000.00	-		Атлах	Татах	
4	Хүчний дасгалын	10	ш	1	435,000.00	435,000.00	435,000.00	-		Атлах	Татах	
5	Хүчний дасгалын	10	ш	1	90,000.00	90,000.00	90,000.00	-		Атлах	Татах	
6	Нярайн жин	8	ш	1	120,000.00	120,000.00	120,000.00	-		Атлах	Устгах	
7	Зөөврийн компьютер	7	ш	1	850,000.00	850,000.00	850,000.00	-		Атлах	Татах	
	<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>			<b>7</b>		<b>3,678,000.00</b>	<b>3,678,000.00</b>					
8	Цэнхэр сандал	11	ш	1	228,000.00	228,000.00	228,000.00	-	эвдэрсэн,	Атлах	Устгах	
	<b>Тавилга, эд хогшлын дүн</b>			<b>1</b>		<b>228,000.00</b>	<b>228,000.00</b>					
	<b>Нийт данснаас хасагдах хөрөнгийн дүн</b>			<b>8</b>		<b>3,906,000.00</b>	<b>3,906,000.00</b>					
	Үүнээс : Татан төвлөрүүлэх хөрөнгө											
	Атлах хөрөнгө											
						348,000.00	348,000.00	-				